TDB · ГАР УТАСНЫ АПП

TDB аппын хэрэглэгчийн заавар

Хувь хүн харилцагчид зориулсан. TDB гар утасны аппаар хийх үйлдэл бүрийн алхамчилсан заавар, дэлгэцийн зурагтай.

ХУВИЛБАР	ОГНОО	ХЭЛ
TDB апп 1.0.2	2026.10.27	Монгол

Агуулга

Нэвтрэх 4

Аппад нэвтрэх 4

Хуучин системээс шилжиж буй харилцагч 4

Шинэ системийн харилцагч 6

HID Approve бүртгүүлэх 12

Нууц үг сэргээх 17

Аппаас гарах 23

Нүүр хуудас 26

Нүүр хуудастай танилцах 26

Данс 33

Данс, дансны тохиргоо 33

Дансны хуулга 42

Данс хайх 46

Дансны тодорхойлолт 49

Данс нээх 52

Данс хаах 56

Хадгаламж 58

Хялбар хуримтлал 58

Миний зорилго 65

Шилжүүлэг 73

Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг 73

IBAN лавлах 79

Гүйлгээний загвар 83

Гадаад шилжүүлэг (SWIFT) 86

MoneyGram илгээх, хүлээн авах 93

Илгээх 93

Хүлээн авах 97

Валютын арилжаа 101

Тогтмол шилжүүлэг 105

Карт 111

Виртуал карт захиалах 111

Дебит карт захиалах 115

Зээл 124

Зээлийн төрлүүд 124

Цалингийн зээл 129

Автомашины зээл 141

Төлбөр 144

Утасны дата, нэгж 144

Билл төлбөр 147

Татвар төлөх 152

Гаалийн төлбөр 156

QR төлбөр 159

QR төлбөр 159

Бусад 161

Хүсэлт илгээх 161

Google Pay холбох 164

Мэдэгдэл 165

Хэрэглэгчийн булан, тохиргоо 168

Нэвтрэх

Аппад нэвтрэх


Хуучин системээс шилжиж буй болон шинэ системийн харилцагч эхний алхамдаа ялгаатай нэвтэрнэ. Нэвтэрсний дараах алхмууд хоёуланд нь ижил.

ЕРӨНХИЙ ДАРААЛАЛ

1. Нэвтрэх нэр, нууц үг
2. Төхөөрөмж баталгаажуулах
3. HID бүртгүүлэх
4. Үндсэн данс сонгох
5. Нүүр хуудас

Хуучин системээс шилжиж буй харилцагч

ДЭЛГЭЦ 1/3 Нэвтрэх нэр, нууц үг



1 Нэвтрэх нэр

Хуучин интернэт банканд ашиглаж байсан нэвтрэх нэрээ оруулна.

2 Нууц үг


Хуучин системд ашиглаж байсан нууц үгээ оруулна.

Нүдний дүрсийг дарж бичсэн нууц үгээ шалгана.

3 Нэвтрэх


Дарж нэвтэрнэ. Анх нэвтэрч буй бол нууц үгээ шинэчлэх мэдэгдэл гарна.


⚠ Алдааны дэлгэц ДЭЛГЭЦ 2/3 **Нэвтрэх нэр эсвэл нууц үг буруу**



1 **Нэвтрэх нэр эсвэл нууц үг буруу байна**
Талбарууд улаанаар тодорч, доор нь мэдэгдэл гарна.

ДЭЛГЭЦ 3/3 **Нууц үг шинэчлэх**





1 **Нууц үг шинэчлэх**
«Системийн шинэчлэл хийсэнтэй холбоотой аюулгүй байдлын үүднээс нууц үгээ шинэчлэнэ үү» гэсэн мэдэгдэл гарна. Нууц үг шинэчлэх-ийг дарна.


2 **Шинэ нууц үг**
Шинэ нууц үгээ оруулна.
8–20 тэмдэгт; багадаа 1 жижиг үсэг, 1 том үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт агуулна; хуучин нууц үгтэй ижил байж болохгүй.

3 **Нууц үг давтах**
Ижил нууц үгээ дахин оруулна.

4 **Дараах**
Шаардлага хангагдсаны дараа идэвхжинэ. Дарж шинэ нууц үгээ хадгална.

Шинэ системийн харилцагч

дэлгэц 1/2 Нэвтрэх хуудас



1 Нэвтрэх нэр

Нэвтрэх нэрээ оруулна.

2 Нууц үг

Нууц үгээ оруулна.

Нүдний дүрсийг дарж бичсэн нууц үгээ харж шалгана.


3 **Нэвтэрч чадахгүй байна уу?**
Нууц үг эсвэл нэвтрэх нэрээ мартсан бол дарж сэргээнэ. → Нууц үг сэргээх (х. 17)

4 **Нэвтрэх**
Хоёр талбар бөглөгдсөний дараа идэвхжинэ. Дарж нэвтэрнэ.

5 **Бүртгүүлэх/Идэвхжүүлэх**
Онлайн банкны бүртгэлгүй эсвэл бүртгэлээ идэвхжүүлээгүй харилцагч эндээс эхэлнэ.

6 **English**
Аппын хэлийг англи болгоно.


⚠ Алдааны дэлгэц ДЭЛГЭЦ 2/2 **Нэвтрэх нэр эсвэл нууц үг буруу**



1 **Нэвтрэх нэр эсвэл нууц үг буруу байна**
Талбарууд улаанаар тодорч, доор нь мэдэгдэл гарна.

Нэвтэрсний дараа: хоёр төрлийн харилцагчид ижил

ДЭЛГЭЦ 1/4 Төхөөрөмж баталгаажуулах



1 Шинэ төхөөрөмж

Тухайн утаснаас анх удаа нэвтэрч байгаа үед гарна.

2 Төхөөрөмж хадгалах

Чагталбал энэ утсыг бүртгэлтэй төхөөрөмж болгон хадгална.

Бүртгэлтэй төхөөрөмжөө Хэрэглэгчийн булан → Аюулгүй байдлын тохиргоо → Бүртгэлтэй төхөөрөмж-өөс харна.

3 **Баталгаажуулах суваг**

Мессеж, И-мэйл эсвэл 2FA баталгаажуулалт (HID Approve)-ын аль нэгийг сонгоно.

Утасны дугаар, и-мэйл хаяг нууцлагдсан хэлбэрээр харагдана. 2FA баталгаажуулалтыг HID бүртгэлтэй харилцагч ашиглана.

4 **OTP код**


Сонгосон суваг руу ирсэн кодыг тоолуур дуусахаас өмнө оруулна.

5 **Баталгаажуулах**

Код бүрэн оруулсны дараа идэвхжинэ. Дарж баталгаажуулна.

⚠ Алдааны дэлгэц ДЭЛГЭЦ 2/4

Утсанд биометрик тохируулаагүй



1 **Биометрик ашиглах боломжгүй**

Утсанд хурууны хээ эсвэл царай таних тохиргоо хийгээгүй үед гарна.

2 **Тохиргоо руу очих**


Утасныхаа тохиргоонд хурууны хээгээ бүртгэнэ.

3 **Цуцлах**

Биометрикгүйгээр үргэлжлүүлнэ.

ДЭЛГЭЦ 3/4

HID бүртгүүлэх санал



1. **HID Approve /2FA Authenticator/**
   HID Approve нь MFA authenticator. HID бүртгэлгүй харилцагч нэвтэрсний дараа гарна.

2. **HID бүртгүүлэх**
   Дарж HID бүртгэлийг эхлүүлнэ. → HID Approve бүртгүүлэх (х. 12)

3. **Алгасах (3 удаа)**
   Одоо бүртгүүлэхгүй бол дарна. Нийт 3 удаа алгасах боломжтой.

   Анхааруулга: 3 удаа алгассаны дараа энэ дэлгэц дахин гарахгүй. Шаардлагатай үед Тохиргоо → Аюулгүй байдлын тохиргоо → Давхар баталгаажуулалт-аас бүртгүүлнэ.

Анхааруулга


Нэг хэрэглэгч HID-г зөвхөн нэг төхөөрөмж дээр бүртгүүлэх боломжтой.

Санамж

Дараа нь үндсэн данс сонгоогүй харилцагчид Үндсэн данс сонгох дэлгэц гарна. Харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн дансаас сонгоно. Алгасвал нэвтрэх бүрд дахин гарна. Үндсэн дансыг дараа нь Дансны тохиргоо-оос өөрчилж болно.

ДЭЛГЭЦ 4/4

Дараагийн удаа нэвтрэх



1. **Хадгалагдсан хэрэглэгч**
   Амжилттай нэвтэрсний дараа харилцагчийн нэр автоматаар хадгалагдаж, нэвтрэх хуудсанд «Тавтай морил, [нэр]» гэж харагдана.
2. **Нэвтрэх**
   Царай эсвэл хурууны хээ тохируулсан бол дарж биометрээр нэвтэрнэ.
3. **Нууц үгээр нэвтрэх**
   Биометр ашиглаагүй бол зөвхөн нууц үгээ оруулж Нэвтрэх-ийг дарна.
4. **Өөр хэрэглэгчээр нэвтрэх**
   Өөр хэрэглэгчээр нэвтрэх бол дарна.
5. **Нэвтрэх нэр, нууц үг**
   Нэвтрэх нэр, нууц үг оруулах талбар гарч ирнэ. Мэдээллээ оруулж нэвтэрнэ.

Амжилттай нэвтэрсний дараа нүүр хуудас нээгдэнэ.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- HID Approve бүртгүүлэх (х. 12)
- Нууц үг сэргээх (х. 17)
- Нүүр хуудастай танилцах (х. 26)

HID Approve бүртгүүлэх


HID Approve нь MFA (олон хүчин зүйлийн баталгаажуулалт) authenticator апп. Бүртгүүлснээр өндөр дүнтэй гүйлгээ баталгаажуулах, нууц үгээ зайнаас солих, нэвтрэх нэрээ сэргээх боломжтой.

ЕРӨНХИЙ ДАРААЛАЛ

1. HID бүртгүүлэх
2. HID Approve апп татах
3. Add service зөвшөөрөх
4. ПИН код зохиох
5. Бүртгэл баталгаажуулах

ДЭЛГЭЦ 1/6 HID бүртгүүлэх

Цэсний зам Нэвтэрсний дараа автоматаар гарна, эсвэл Тохиргоо → Аюулгүй байдлын тохиргоо → Давхар баталгаажуулалт



1. **Давуу тал**
   Өндөр дүнтэй гүйлгээ баталгаажуулах, нууц үгээ зайнаас шинэчлэх, нэвтрэх нэрээ сэргээхэд ашиглана.
2. **HID бүртгүүлэх**
   Дарж бүртгэлийн зааврыг нээнэ.
3. **Алгасах (3 удаа)**
   Одоо бүртгүүлэхгүй бол дарна.


Анхааруулга

Нэг хэрэглэгч HID-г зөвхөн нэг төхөөрөмж дээр бүртгүүлэх боломжтой.

Анхааруулга


Нэвтрэх үед HID бүртгүүлэх дэлгэцийг бүртгэл хийхгүйгээр 3 удаа алгасах боломжтой. 3 удаа алгассаны дараа энэ дэлгэц дахин гарахгүй. Шаардлагатай үед Тохиргоо → Аюулгүй байдлын тохиргоо → Давхар баталгаажуулалт-аас бүртгүүлнэ.

ДЭЛГЭЦ 2/6 Бүртгэлийн заавар




1. **1. HID Approve апп татах**
   App Store (Android утсанд Play Store)-оос HID Approve аппыг татаж суулгана.
2. **2. Бүртгэл зөвшөөрөх**
   HID Approve апп дээр гарах Add service асуултад Yes-ийг дарна.
3. **3. ПИН код зохиох**
   Цаашид ашиглах 4 оронтой ПИН кодоо зохионо.
4. **4. Бүртгэл шалгах**
   Бүртгэл амжилттай болсон мэдэгдэл гарсан эсэхийг шалгана.
5. **Ойлголоо**
   Дарж HID Approve апп татах хуудас руу шилжинэ.

ДЭЛГЭЦ 3/6 HID Approve апп татах



1. **Татах**
   HID Approve аппыг татаж суулгана.
   Апп аль хэдийн суулгасан бол энэ алхам алгасагдаж, шууд Add service асуулт гарна.

ДЭЛГЭЦ 4/6 **HID Approve апп дээр бүртгэх**



1 **Add service**

«TDB would like to add a new service» асуултад Yes-ийг дарна.

2 **Set PIN**

4 оронтой ПИН кодоо оруулж, давтан баталгаажуулаад OK-г дарна.


ПИН код зөвхөн 4 тоо байх ба дараалсан тоо (жишээ нь 1234) зөвшөөрөхгүй. Цаашид HID Approve-д энэ кодыг ашиглана.

3 **Бүртгэл амжилттай**

«TDB approve service has been registered successfully» гарвал Ok-г дарж TDB апп руу буцна.

ДЭЛГЭЦ 5/6


Бүртгэл баталгаажуулах



1. **Тийм, суулгасан**
   TDB апп руу буцаж ирээд HID апп дээрх бүртгэлээ дуусгасан бол дарна.

2. **Амжилттай бүртгэгдлээ**
   Төхөөрөмж бүртгэгдэж, цаашид энэ утсаар баталгаажуулалт хийх боломжтой боллоо. Үргэлжлүүлэх-ийг дарна.

⚠ Алдааны дэлгэц ДЭЛГЭЦ 6/6 **Бүртгэл зөвшөөрөгдөөгүй**



1. **Та хараахан бүртгэлийг зөвшөөрөөгүй байна**
   HID апп дээрх бүртгэл дуусаагүй байхад Тийм, суулгасан-ыг дарвал гарна.

2. **Дахин оролдох**
   Дарахад HID аппыг татсан эсэхээс хамаарч дараагийн дэлгэц гарна.

3. **Апп татаагүй бол**
   HID Approve аппын татах хуудас нээгдэнэ. Аппаа татаж суулгана.

4. **Апп татсан бол**
   HID апп дээр Add service асуулт гарна. Yes-ийг дарж бүртгэлээ үргэлжлүүлнэ.

> Бүртгэл амжилттай болсны дараа гүйлгээ болон нууц үг сэргээх зэрэгт HID Approve-оор баталгаажуулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Аппад нэвтрэх (х. 4)
- Хэрэглэгчийн булан, тохиргоо (х. 168)
- Нууц үг сэргээх (х. 17)

Нууц үг сэргээх


Нууц үгээ мартсан эсвэл блоклогдсон бол нэвтрэх хуудаснаас регистрийн дугаар болон баталгаажуулах кодоор сэргээнэ.


ЕРӨНХИЙ ДАРААЛАЛ

1. Нэвтэрч чадахгүй байна уу?
2. Нууц үг сэргээх
3. Нэвтрэх нэр
4. Баталгаажуулах
5. Нууц үг сэргээгдлээ

ДЭЛГЭЦ 1/8 Нэвтэрч чадахгүй байна уу?


Цэсний зам Нэвтрэх хуудас → Нэвтэрч чадахгүй байна уу? → Нууц үг сэргээх





1. **Нэвтэрч чадахгүй байна уу?**
   Нэвтрэх хуудаснаас дарна.
2. **Нууц үг сэргээх**
   Нууц үгээ мартсан эсвэл блоклогдсон бол сонгоно.

ДЭЛГЭЦ 2/8 Нэвтрэх нэр, регистр




1. **Нэвтрэх нэр**
   Нэвтрэх нэрээ оруулаад Үргэлжлүүлэх-ийг дарна.
2. **Регистрийн үсэг**
   Хоёр нүдийг дарж регистрийн эхний 2 үсгийг сонгоно.
3. **Үсэг сонгох**
   Гарч ирэх үсгийн жагсаалтаас дарж сонгоно.
4. **Регистрийн дугаар**
   Регистрийн 8 оронтой тоогоо оруулна.

5 **Гадаадын иргэн**
Гадаадын иргэн бол энэ холбоосоор орж бүртгэлийн дугаараа оруулна.

6 **Байгууллагын харилцагч**
Байгууллагын харилцагч бол энэ холбоосоор орж байгууллагын регистрийн дугаараа оруулна.

7 **Үргэлжлүүлэх**
Регистрийн дугаар бүрэн оруулсны дараа идэвхжинэ. Дарж баталгаажуулах алхам руу шилжинэ.

ДЭЛГЭЦ 3/8 **Гадаадын иргэн**




1 **Паспортын дугаар**
«Гадаадын иргэн бол энд дарна уу» дарахад регистрийн оронд паспортын дугаар оруулах талбар гарна. Паспортын дугаараа оруулна.

2 **Үргэлжлүүлэх**
Дугаар оруулсны дараа идэвхжинэ. Дарж баталгаажуулах алхам руу шилжинэ.

ДЭЛГЭЦ 4/8

Байгууллагын харилцагч




1 **Байгууллагын дугаар**
«Байгууллагын харилцагч бол энд дарна уу» дарахад байгууллагын регистрийн дугаар оруулах талбар гарна.

2 **Үргэлжлүүлэх**
Дугаар оруулсны дараа идэвхжинэ. Дарж баталгаажуулах алхам руу шилжинэ.

⚠ Алдааны дэлгэц


ДЭЛГЭЦ 5/8


Таны оруулсан мэдээлэл буруу



1 **Таны оруулсан мэдээлэл буруу байна**
Оруулсан нэвтрэх нэр хуучин болон шинэ системийн аль алинд бүртгэлгүй үед гарна.


ДЭЛГЭЦ 6/8 Баталгаажуулах






1. **Мессеж**
   Бүртгэлтэй утасны дугаарт SMS-ээр код авна.
2. **И-мэйл**
   Бүртгэлтэй и-мэйл хаягт код авна.
3. **HID approve**
   HID бүртгэлтэй бол HID Approve аппаар баталгаажуулна. → HID Approve бүртгүүлэх (х. 12)
4. **Нэг удаагийн код**
   Ирсэн 4 оронтой кодыг тоолуур дуусахаас өмнө оруулна.

ДЭЛГЭЦ 7/8 Шинэ нууц үг






1. **Шинэ нууц үг**
   Шинэ нууц үгээ оруулна.
2. **Шаардлага**
   Бүх шаардлага чагтлагдсан байх ёстой.
   8–20 тэмдэгт, багадаа 1 жижиг үсэг, 1 том үсэг, 1 тоо, 1 тэмдэгт агуулсан, хуучин нууц үгээс өөр байна.
3. **Нууц үгээ давтах**
   Ижил нууц үгийг дахин оруулна.
4. **Дараах**
   Бүх шаардлага хангагдсаны дараа идэвхжинэ. Дарж шинэ нууц үгээ хадгална.

ДЭЛГЭЦ 8/8

Амжилттай сэргээгдлээ



1 Нэвтрэх

Шинэ нууц үгээрээ нэвтэрнэ. → **Аппад нэвтрэх · Шинэ системийн харилцагч** (х. 6)

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Аппад нэвтрэх (х. 4)
- HID Approve бүртгүүлэх (х. 12)


Аппаас гарах


Хэрэглэгчийн булангаас аппаас гарна.


ДЭЛГЭЦ 1/1 Гарах

Цэсний зам Нүүр хуудас → зүүн дээд булангийн профайлын дүрс → Гарах









1 **Профайл**
Нүүр хуудасны зүүн дээд булангийн дүрсийг дарна.

2 **Гарах**
Хэрэглэгчийн булангийн хамгийн доор байрлах Гарах-ыг дарна.

3 **Тийм, системээс гарах**
«Системээс гарах гэж байна» гэсэн цонхонд дарна. Болих бол Цуцлах-ыг дарна.

4 **Нэвтрэх дэлгэц**
Системээс гарахад нэвтрэх дэлгэц нээгдэнэ.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Аппад нэвтрэх (x. 4)
- Хэрэглэгчийн булан, тохиргоо (x. 168)


Нүүр хуудас

Нүүр хуудастай танилцах

Нэвтэрсний дараа нээгдэх нүүр хуудаснаас үлдэгдэл, сүүлийн гүйлгээ харж, Үйлчилгээ цэсээр бүх үйлчилгээ рүү шилжинэ.

ДЭЛГЭЦ 1/5

Нүүр хуудас



1. **Үндсэн данс**
   Үндсэн дансны дугаар, үлдэгдэл харагдана.
   Дугаарын хажуугийн дүрсээр дансны дугаарыг хуулна. Дансны хуучин дугаар «хуучин» тэмдэглэгээтэйгээр дээр нь харагдана.

2. **Үлдэгдэл нуух**
   Нүдний дүрсээр үлдэгдлийг нууж, харуулна.

3. **Мэдэгдэл**
   Банкнаас ирсэн мэдэгдлээ харна.

4. **Хуулга, данс хайх**
   Дансны хуулга болон хуучин дугаараар данс хайх. → Дансны хуулга (х. 42)

5. **Түргэн цэс**
   Данс, Зээл, Карт, Хэрэглээ.


6. **Сүүлийн гүйлгээ**
   Сүүлийн гүйлгээнүүд. Бүгдийг Хуулга-аас харна.

7. **Гүйлгээний дэлгэрэнгүй**
   Гүйлгээг дарахад дүн, гүйлгээний төрөл, утга, журнал дугаар, огноо харагдана.

8. **Доод цэс**
   Нүүр, QR төлбөр, Шилжүүлэг, Үйлчилгээ.


ДЭЛГЭЦ 2/5 **Үйлчилгээ цэс**





1. **Үйлчилгээ**
   Доод цэсний Үйлчилгээ-г дарна.
2. **Хайх**
   Үйлчилгээг нэрээр нь хайна.
3. **Түгээмэл үйлчилгээ**
   Зээл, Тодорхойлолт руу шууд орно.
4. **Байнга ашиглах**
   Нэмэх, Засах-аар байнга хэрэглэдэг үйлчилгээгээ энд гаргана.
5. **Бүгд**
   Бүх үйлчилгээг ангиллаар нь харна.

ДЭЛГЭЦ 3/5 **Үйлчилгээ хайх**



1 **Хайх**

Үйлчилгээний нэрийн эхний хэдэн үсгийг бичихэд тохирох үйлчилгээ шүүгдэнэ.


2 **Илэрц**

Жишээ нь «Шилжүүлэг» гэж бичихэд Тогтмол шилжүүлэг гарна. Дарж шууд нээнэ.

3 **Өөр жишээ**

«Зээл» гэж бичихэд зээлийн бүх үйлчилгээ гарна.

Байнга ашиглах



1 Байнга ашиглах
Байнга хэрэглэдэг үйлчилгээгээ энд нэмж, нэг товшилтоор нээнэ.

2 Нэмэх
Дарж нэмэх үйлчилгээгээ сонгоно.


3 Засах
Байнга ашиглах жагсаалтаа засна.


4 Хадгалсан
Нэмсэн үйлчилгээнүүдийн жагсаалт. Хасах бол улаан дүрсийг дарна.

5 Нэмэх, Хаах
Нэмэх-ээр өөр үйлчилгээ нэмнэ, жишээ нь Автомашины зээл нэмэгдлээ. Хаах-аар цонхыг хаана.

ДЭЛГЭЦ 5/5

Бүх үйлчилгээ





1 **Ангилал**
Дээд талын табаар Данс, Хадгаламж, Шилжүүлэг, Карт, Зээл, Төлбөр, Бусад ангиллыг сонгоно. Табыг хажуу тийш гүйлгэж бүгдийг харна.

2 **Данс**
Дансны жагсаалт, Тодорхойлолт, Данс нээх, Данс хаах.

3 **Хадгаламж**
Хялбар хуримтлал, Миний зорилго, Хугацаа цуцлах.

4 **Шилжүүлэг**
Тогтмол шилжүүлэг, Загварын жагсаалт.

5 **Карт**
Картын жагсаалт.

6 **Зээл**
Хадгаламж барьцаалах, Цалингийн зээл, Тэтгэврийн зээл, Автомашины зээл, Посын орлого барьцаалах, Хэрэглээний цахим зээл.

7 **Төлбөр**
Нэгж, дата, Утас, хэрэглээний төлбөр, Татвар, Гааль.

8 **Бусад**
Хүсэлтийн жагсаалт, Кастодиан.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Данс, дансны тохиргоо (x. 33)
- Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (x. 73)


Данс


Данс, дансны тохиргоо

Дансны жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл харж, товч нэр өгөх, нуух, үндсэн данс сонгох, дансны нэгдсэн санд бүртгүүлэх тохиргоо хийнэ.

ДЭЛГЭЦ 1/7 Дансны жагсаалт

Цэсний зам Нүүр хуудас → Данс






1. **Данс**
   Нүүр хуудасны Данс цэсийг дарна.
2. **Данс сонгох**
   Дансаа дарж дэлгэрэнгүйг нээнэ.
   Мөрийн баруун талын дүрсээр дансны дугаарыг хуулна.

ДЭЛГЭЦ 2/7

Дансны дэлгэрэнгүй



1 **Үлдэгдэл, дугаар**
Дансны төрөл, үлдэгдэл, IBAN дугаар харагдана.

2 **Үлдэгдэл нуух**
Баруун дээд булангийн нүдний дүрсийг дарж үлдэгдлээ нууна. Дахин дарвал үлдэгдэл харагдана.

3 **Хуулга, Шилжүүлэг**
Энэ данснаас хуулга харах, шилжүүлэг хийх товч.


4 **Сүүлийн гүйлгээ**
Дэлгэрэнгүй харах-аар хуулга нээгдэнэ.

5 **Тохиргоо**
Дансны тохиргоог нээнэ.

ДЭЛГЭЦ 3/7

Дансны мэдээлэл

Цэсний зам Данс → данс сонгох → Тохиргоо → Дэлгэрэнгүй мэдээлэл




1 Дэлгэрэнгүй мэдээлэл
Дансны Тохиргоо-оос сонгоно.

2 Дансны мэдээлэл
Шинэ, хуучин IBAN, нээсэн огноо, салбар, төлөв, үлдэгдэл, битүүмжилсэн дүн харагдана.

ДЭЛГЭЦ 4/7

Товч нэр өгөх

Цэсний зам Данс → данс сонгох → Тохиргоо → Дансны товч нэр өөрчлөх, эсвэл Данс → дансны жагсаалтын баруун дээд булангийн Дансны тохиргоо → Дансны товч нэр



1 **Дансны товч нэр өөрчлөх**
Дансны Тохиргоо-оос сонгоно.


2 **Данс сонгох**
Нэр өгөх дансаа дарна.


3 **Товч нэр**
Дансанд өгөх нэрээ бичнэ.

4 **Бүртгэх**
Дарж товч нэрээ хадгална.

ДЭЛГЭЦ 5/7 **Дансаа нуух, харуулах**

Цэсний зам Данс → данс сонгох → Тохиргоо → Дансаа нуух, харах, эсвэл Данс → дансны жагсаалтын баруун дээд булангийн Дансны тохиргоо → Дансаа нуух, харах






1 Дансаа нуух, харах
Дансны Тохиргоо-оос сонгоно.


2 Нуух / харах
Дансны товчийг асааж, унтраана. Унтраасан данс жагсаалтад харагдахгүй.

ДЭЛГЭЦ 6/7

Үндсэн данс сонгох

Цэсний зам Данс → данс сонгох → Тохиргоо → Үндсэн данс сонгох, эсвэл Данс → дансны жагсаалтын баруун дээд булангийн Дансны тохиргоо → Үндсэн данс сонгох





1 **Үндсэн данс сонгох**

Нүүр хуудас болон гүйлгээнд анхдагчаар харагдах дансаа сонгоно. Харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн дансаас сонгоно.

Үндсэн данс сонгоогүй харилцагчид нэвтрэх бүрд Үндсэн данс сонгох дэлгэц гарна.

2 **Данс сонгох**

Үндсэн болгох дансныхаа сонгох товчийг дарна.

3 **Сонгох**

«Та дээрх дансыг үндсэн данс болгох уу?» асуултад «Сонгох»-ыг дарна.


4 **Бүртгэл амжилттай**

Сонгосон данс үндсэн дансаар бүртгэгдэнэ. «Нүүр хуудас»-ыг дарж буцна.

ДЭЛГЭЦ 7/7

Дансны нэгдсэн сан

Цэсний зам Данс → дансны жагсаалтын баруун дээд булангийн Дансны тохиргоо → Дансны нэгдсэн сан



1 **Дансны тохиргоо**

Дансны жагсаалтын баруун дээд булангийн тохиргооны дүрсийг дарна.

2 **Дансны нэгдсэн сан**

«Орлох дугаар сонгох» гэсэн Дансны нэгдсэн сан-г сонгоно.

3 **ДНС-д бүртгэх**

Данс болон орлох дугаар харагдана. «ДНС-д бүртгэх»-ийг дарна.

4 **Данс, орлох дугаар**

Бүртгэх данс болон орлох дугаараа (утас эсвэл и-мэйл) сонгоно.

Утас эсвэл и-мэйлээ солих бол «Мэдээлэл шинэчлэх»-ийг дарна.

5 **Хадгалах**

Дарж дансаа дансны нэгдсэн санд бүртгэнэ.

6 **Бүртгэл амжилттай**

Данс дансны нэгдсэн санд амжилттай бүртгэгдлээ. «Нүүр хуудас»-ыг дарж буцна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Дансны хуулга (х. 42)
- Данс хаах (х. 56)
- Дансны тодорхойлолт (х. 49)

Дансны хуулга

Дансны гүйлгээг хугацаагаар шүүж харах, гүйлгээний дэлгэрэнгүйг нээх, хуулгаа и-мэйлээр авна.

ДЭЛГЭЦ 1/3 Хуулга харах

Цэсний зам Нүүр хуудас → Дансны хуулга, эсвэл Данс → данс сонгох → Хуулга



1 Дансны хуулга

Нүүр хуудаснаас дарна.

Дансны дэлгэрэнгүйн Хуулга-аас ч нээнэ.

2 Огноо

Эхлэх, дуусах огноогоо сонгоно.

3 Огноо сонгох

Он, сар, өдрөө гүйлгэж сонгоод «Үргэлжлүүлэх»-ийг дарна.

4 Хугацаа

7 хоног, 1 сар, 3 сараар шүүнэ.


5 Хайх

Гүйлгээний утга, дүнгээр хайна.

6 Бүгд, Орлого, Зарлага
Гүйлгээний чиглэлээр шүүнэ.

7 Гүйлгээ сонгох
Гүйлгээг дарж дэлгэрэнгүйг нээнэ.


ДЭЛГЭЦ 2/3 Гүйлгээний дэлгэрэнгүй



1 Гүйлгээний дэлгэрэнгүй
Төрөл, харьцсан данс, банк, утга, журналын дугаар, огноо, үлдэгдэл.

ДЭЛГЭЦ 3/3

Хуулга и-мэйлээр авах



1. **Татах**
   Баруун дээд буланги Татах-ыг дарна.

2. **Файлын төрөл**
   Excel, PDF эсвэл QR баталгаажсан PDF-ээс сонгоно.

3. **Илгээгдлээ**
   Хуулга бүртгэлтэй и-мэйл хаягт очно.
   Ирээгүй бол и-мэйлийн spam хавтсаа шалгана.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Данс, дансны тохиргоо (х. 33)
- Дансны тодорхойлолт (х. 49)

Данс хайх

Системийн шинэчлэлтээр дансны дугаар өөрчлөгдсөн. Хуучин дугаараараа шинэ дугаараа олно.

ДЭЛГЭЦ 1/1 Хуучин, шинэ дугаар

Цэсний зам Нүүр хуудас → Данс хайх



1 **Данс хайх**
Нүүр хуудаснаас дарна.

2 **Хуучин, шинэ дугаар**
Данс бүрийн хуучин болон шинэ дугаар харагдана.

3 **Дугаараар хайх**
Хуучин эсвэл шинэ дугаараа оруулна.

4 **Хуулах**
IBAN дугаарыг хуулна.

5 **Ойлголоо**
Дарж өмнөх хуудас руу буцна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Данс, дансны тохиргоо (x. 33)

Дансны тодорхойлолт

Дансны тодорхойлолтыг аппаас захиалж, бүртгэлтэй и-мэйл хаягаараа авна.

ДЭЛГЭЦ 1/3 Төрөл сонгох

Цэсний зам Үйлчилгээ → Тодорхойлолт, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Данс → Тодорхойлолт



1 Тодорхойлолт

Үйлчилгээ цэсний Тодорхойлолт-ыг дарна.

2 Тодорхойлолтын төрөл

Хэрэгтэй төрлөө сонгоно.


Үлдэгдэлтэй, үлдэгдэлгүй, үлдэгдлийн баталгаа, ЭСЯ-нд зориулсан, зээлийн төлбөрийн гэх мэт төрөл бий.

3 Санамж

Үлдэгдэлтэй, ЭСЯ-нд зориулсан зэрэг тодорхойлолтыг сонгоход «Таны дансанд 24 цагийн хугацаатай битүүмж тавигдахыг анхаарна уу» гэсэн санамж гарна. «Ойлголоо»-г дарж үргэлжлүүлнэ.

ДЭЛГЭЦ 2/3

Мэдээлэл бөглөх



1. **Данс**
   Тодорхойлолт гаргах дансаа сонгоно.

2. **Хэл сонгох**
   Дарж хэлний жагсаалтыг нээнэ.


3. **Монгол эсвэл Англи**
   Жагсаалтаас Монгол эсвэл Англи хэлийг сонгоно.

4. **Хэнд**
   Тодорхойлолтыг хаана өгөхийг бичнэ.

5 **Дараах**

Мэдээллээ шалгаад дарж хүсэлтээ илгээнэ.

ДЭЛГЭЦ 3/3 **Илгээгдлээ**



1 **Илгээгдлээ**

Тодорхойлолт бүртгэлтэй и-мэйл хаягт очно.

2 **Татах**

Тодорхойлолтыг утсандаа татаж хадгална.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Дансны хуулга (х. 42)
- Данс, дансны тохиргоо (х. 33)


Данс нээх


Харилцах болон хадгаламжийн данс аппаас шууд нээнэ.


ДЭЛГЭЦ 1/2 **Дансны төрөл, валют**


Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Данс → Данс нээх



5:15
3G
Үйлчилгээ
Данс
Хадгаламж
Шилжүүлэг
Карт
Зээл
Дансны үйлчилгээнүүд
Дансны жагсаалт
Тодорхойлолт
1
Данс нээх
Данс хаах



5:15
3G
Шинээр данс нээх
2
Дансны үндсэн төрөл
Үргэлжлүүлэх
Нүүр хуудас


5:15
3G
Шинээр данс нээх
Дансны үндсэн төрөл
Дансны үндсэн төрөл
3
Харилцах данс
Хугацаагүй хадгаламж
Хугацаатай хадгаламж


5:15
3G
Шинээр данс нээх
Дансны үндсэн төрөл
Харилцах данс
4
Дансны валют
Үргэлжлүүлэх
Нүүр хуудас


5:15
3G
Шинээр данс нээх
Дансны үндсэн төрөл
Харилцах данс
Валют сонгох
5
MNT
USD
EUR
CNY
JPY
AUD
CAD
GBP
CHF


5:17
3G
Шинээр данс нээх
Дансны үндсэн төрөл
Хугацаатай хадгаламж
Валют сонгох
6
Хадгаламжийн төрөл
Хадгаламжийн хугацаа
Холбох данс
Дансны доод үлдэгдэл
Үргэлжлүүлэх



1. **Данс нээх**
   Үйлчилгээ → Бүгд → Данс ангиллаас сонгоно.

2. **Дансны төрөл**
   Дарж жагсаалтыг нээнэ.

3. **Төрөл сонгох**
   Харилцах данс, хугацаагүй эсвэл хугацаатай хадгаламжаас сонгоно.

4. **Дансны валют**
   Дарж жагсаалтыг нээнэ.


5. **Валют сонгох**
   MNT, USD, EUR, CNY гэх мэт валютаас сонгоно.

6. **Хугацаатай хадгаламж**
   Хугацаатай хадгаламж сонгосон бол Хадгаламжийн төрөл, Хадгаламжийн хугацаа, Холбох данс талбарыг нэмж бөглөнө.

7. **Үргэлжлүүлэх**
   Дарж данс нээнэ.

ДЭЛГЭЦ 2/2

Данс үүслээ



1 Амжилттай үүслээ

Шинэ дансны дугаар дэлгэц дээр гарна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Данс, дансны тохиргоо (х. 33)
- Данс хаах (х. 56)

Данс хаах

Хэрэглэхээ больсон дансаа хааж, үлдэгдлийг өөрийн өөр данс руу шилжүүлнэ.

ДЭЛГЭЦ 1/2 Хаах нөхцөл, шалтгаан

Цэсний зам Данс → Тохиргоо → Данс хаах, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Данс → Данс хаах



1. **Данс хаах**
   Дансны Тохиргоо-оос сонгоно.


2. **Хаах нөхцөл**
   Идэвхтэй карт, хамтран эзэмшигч, зээл, битүүмж байгаа, цалингийн эсвэл хадгаламжтай холбоотой данс хаагдахгүй.

3. **Шалтгаан**
   Дарж жагсаалтыг нээнэ.

4. **Шалтгаан сонгох**
   Тохирох шалтгаанаа сонгоно.

ДЭЛГЭЦ 2/2

Үлдэгдэл шилжих данс



1 **Данс сонгох**

Үлдэгдэл шилжих дансаа сонгох жагсаалтыг нээнэ.

2 **Хүлээн авах данс**

Өөрийн өөр дансаа сонгоно.

3 **Шалгах**

Шалтгаан, хүлээн авах данс, хаах шимтгэлээ шалгана.

4 **Баталгаажуулах**

Дарахад данс хаагдаж, үлдэгдэл сонгосон данс руу шилжинэ.

⚠ Сүүлийн алхам: дарсны дараа данс хаагдана

> Санамж
>
> Баталгаажуулахаас өмнө хаах данс болон үлдэгдэл хүлээн авах дансаа сайтар шалгана.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Данс, дансны тохиргоо (х. 33)
- Данс нээх (х. 52)


Хадгаламж

Хялбар хуримтлал

Сонгосон данснаас хадгаламжийн данс руу тогтмол дүнг автоматаар шилжүүлэх тохиргоо.

ДЭЛГЭЦ 1/4 Хуримтлалын төрөл


Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Хадгаламж → Хялбар хуримтлал



1. **Хялбар хуримтлал**
   Хадгаламж ангиллаас сонгоно.
2. **Хялбар хуримтлал үүсгэх**
   Дарж шинэ хуримтлал үүсгэнэ.
3. **Төрөл сонгох**
   Тогтмол, орлого бүрээс, өдөр бүр эсвэл харилцаа хадгалья-аас сонгоно.

ДЭЛГЭЦ 2/4

Хуримтлалын дүн



1 Хуримтлуулах дүн

Нэг удаад шилжих дүнгээ оруулна.

2 Давтамж

Дарж жагсаалтыг нээнэ.

3 Давтамж сонгох

Өдөр бүр, долоо хоног бүр, хагас сар бүр эсвэл сар бүр.


4 Шилжүүлэг хийх өдөр

Дарж өдрөө сонгоно.

5 **Өдөр сонгох**
Сарын хэдэнд шилжүүлэхийг сонгоно.

6 **Үргэлжлүүлэх**
Дарж дансны мэдээлэл оруулах алхам руу шилжинэ.

Дансны мэдээлэл




1. **Илгээх данс**
   Мөнгө хасагдах дансаа сонгоно.
2. **Данс сонгох**
   Жагсаалтаас дансаа дарж сонгоно.
3. **Хүлээн авах данс**
   Мөнгө хуримтлагдах хадгаламжийн дансаа сонгоно.
4. **Бүртгэл үүсгэх**
   Дарж хуримтлалаа бүртгэнэ.

5 **Дуусгах**

Амжилттай бүртгэгдсэний дараа дарна.

ДЭЛГЭЦ 4/4

Засах, устгах



1. **Хуримтлал сонгох**
   Засах эсвэл устгах хуримтлалаа жагсаалтаас дарна.

2. **Засах**
   Дүн, давтамж, өдөр, хүлээн авах дансаа өөрчилнө.

3. **Хадгалах**
   Өөрчлөлтөө хадгална.

4. **Устгах**
   Хуримтлалыг зогсооно.

5 **Зөвшөөрөх**
Дарж устгалыг баталгаажуулна.

6 **Устгагдлаа**
Цаашид автомат шилжүүлэг хийгдэхгүй.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Миний зорилго (x. 65)
- Тогтмол шилжүүлэг (x. 105)

Миний зорилго

Зорилготой хадгаламжийн данс нээж, зорилтот дүн, хугацаатайгаар мөнгө хуримтлуулна.


ДЭЛГЭЦ 1/7 Зорилтот дүн

Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Хадгаламж → Миний зорилго




1. **Миний зорилго**
   Хадгаламж ангиллаас сонгоно.
2. **Данс нээх**
   Шинэ зорилго үүсгэнэ.
3. **Зорилтот дүн**
   Хуримтлуулах дүнгээ товчлууруар оруулна.
4. **Үргэлжлүүлэх**
   Дарж дараагийн алхам руу шилжинэ.

Төрөл, нэр



1. **Зорилгын төрөл**
   Хажуу тийш гүйлгэж сонгоно.
2. **Үргэлжлүүлэх**
   Төрлөө сонгоод дарна.
3. **Зорилгын нэр**
   Зорилгодоо нэр өгнө.
4. **Үргэлжлүүлэх**
   Нэрээ оруулаад дарна.

Хугацаа, данс



1 **Дуусах хугацаа**
Дарж огноо сонгоно.

2 **Огноо сонгох**
Он, сар, өдрөө гүйлгэж Сонгох-ыг дарна.

3 **Хадгаламжийн хүү**
Хугацаанаас хамаарч автоматаар гарна.


4 **Данс сонгох**
Холбох дансаа сонгох жагсаалтыг нээнэ.

5 Холбох данс
Хадгаламж дуусахад мөнгө шилжих данс.

6 Тогтмол шилжүүлэг
Асаавал холбосон данснаас тогтмол мөнгө шилжинэ.

7 Үргэлжлүүлэх
Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 4/7 Гэрээ баталгаажуулах





1 Гэрээтэй танилцах
Гэрээг үншаад чагтална.

2 Баталгаажуулах
Дарж зорилгоо үүсгэнэ.

3 Амжилттай үүслээ
Шинэ зорилго бүртгэгдлээ.

Зорилгоо харах






1 Зорилго сонгох
Нээлттэй зорилгуудаас дарна.

2 Зорилгын дэлгэрэнгүй
Хугацаа, дансны дугаар, зорилтот болон биелсэн дүн, биелэлтийн хувь.

Засах



1 Тохиргоо

Баруун дээд буланги дүрсийг дарна.


2 Засах

Цэснээс Засах-ыг сонгоно.

3 Зорилго засах

Нэр, дүн, холбосон данс, тогтмол шилжүүлгийг өөрчлөөд Хадгалах-ыг дарна.

Хугацаанаас өмнө цуцлах



1. **Хугацаанаас өмнө цуцлах**
   Тохиргооноос сонгоно.
2. **Анхааруулга**
   Хүү гэрээний нөхцөлийн дагуу буурна. Барьцаалсан зээлтэй бол зээл төлөгдөнө.
3. **Цуцлах**
   Анхааруулгыг уншаад дарна.
4. **Цуцлахыг батлах**
   Дахин Цуцлах-ыг дарна.

5 **Төхөөрөмжөөр баталгаажуулах**

Бүртгэлтэй төхөөрөмжөө сонгож баталгаажуулснаар зорилго цуцлагдана.

⚠ Сүүлийн алхам: баталгаажуулсны дараа зорилго цуцлагдана

> Санамж
>
> Хугацаанаас өмнө цуцалбал хадгаламжийн хүү гэрээний нөхцөлийн дагуу бүурч, данс шууд хаагдана.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Хялбар хуримтлал (х. 58)
- Данс нээх (х. 52)


Шилжүүлэг


Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг


Шилжүүлэг цэсээс өөрийн данс хооронд болон бусдын данс руу банк дотор шилжүүлнэ.


ДЭЛГЭЦ 1/4 **Дүн оруулах**

Цэсний зам Доод цэс → Шилжүүлэг










1 **Шилжүүлэг**
Доод цэснээс дарна.

2 **Илгээх данс**
Мөнгө хасагдах дансаа сонгоно.

3 **Дүн**
Товчлуураар шилжүүлэх дүнгээ оруулна.

4 **Шилжүүлэх**
Дүнгээ шалгаад дарж хүлээн авагчаа оруулна.

Хүлээн авагч



1 **Бусдын данс**
IBAN дугаар оруулахад дансны нэр гарна. → IBAN лавлах (х. 79)
Утасны дугаар-ыг асааж утасны дугаараар шилжүүлж болно.

2 **Өөрийн данс**
Өөрийн данс руу бол энэ табыг сонгоно.


3 **Хүлээн авах данс**
Жагсаалтаас өөрийн дансаа сонгоно.

4 **Хүлээн авах дүн**
Өөр валюттай данс руу шилжүүлэхэд хөрвүүлсэн дүн, ханш гарна.

5 **Гүйлгээний утга**
Утгаа бичих эсвэл доорх бэлэн утгаас сонгоно.

6 **Үргэлжлүүлэх**
Мэдээллээ бөглөөд дарна.

ДЭЛГЭЦ 3/4 **Баталгаажуулах**




1 **Шалгах**
Илгээх, хүлээн авах данс, дүн, утгаа шалгана.

2 **Гүйлгээ хийх**
Дарж шилжүүлнэ.

ДЭЛГЭЦ 4/4

Гүйлгээ амжилттай



1 **Гүйлгээ амжилттай**
Дүн, хүлээн авагчийн данс харагдана.

2 **Загвар хадгалах**
Дараа дахин ашиглах бол загвар болгоно. → Гүйлгээний загвар (х. 83)

3 **Загварын нэр**
Загварт нэр өгнө.

4 **Хадгалах**
Дарж загвараа хадгална.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Гүйлгээний загвар (х. 83)
- Тогтмол шилжүүлэг (х. 105)
- Валютын арилжаа (х. 101)

IBAN лавлах

Хүлээн авагчийн IBAN дугаарыг мэдэхгүй бол шилжүүлгийн хуудаснаас дансны дугаараар хайж олоод хүлээн авагчийн талбарт хуулна.

ДЭЛГЭЦ 1/3 **IBAN лавлагаа**

Цэсний зам Шилжүүлэг → дүн → Шилжүүлэх → Бусдын данс → IBAN



1 IBAN

Хүлээн авагчийн хуудасны баруун дээд булангийн IBAN-ыг дарна.

2 Дансны дугаар, Орлох дугаар

Дансны дугаараар хайх бол Дансны дугаар табыг сонгоно. Орлох дугаар табаар орлох дугаараар хайна.

3 Дансны дугаар


Хүлээн авагчийн дансны дугаарыг оруулна.


4 Хайх

Дарж IBAN дугаарыг хайна.

ДЭЛГЭЦ 2/3

Хайлтын үр дүн






1. **IBAN, эзэмшигчийн нэр**
   IBAN дугаар, данс эзэмшигчийн нэр гарна. Хүлээн авагчийн нэр зөв эсэхийг шалгана.

2. **Хүүлах**
   Дарж IBAN-ыг хүлээн авагчийн талбарт хүүлна.

3. **Амжилттай хүүллаа**
   IBAN дугаар, банк, эзэмшигчийн нэр бөглөгдөнө.

4. **Үргэлжлүүлэх**
   Дүн, утгаа шалгаад дарж шилжүүлгээ үргэлжлүүлнэ. → Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (x. 73)

⚠ Алдааны дэлгэц ДЭЛГЭЦ 3/3 **IBAN олдсонгүй**



1 **Банк сонгох**
IBAN олдоогүй бол банк сонгох хэсэг нэмэлтээр гарна.

2 **Банк сонгоод хайх**
Хүлээн авагчийн банкыг сонгоод Хайх-ыг дахин дарна.

3 **Дансаа шалгаад дахин оролдоно уу**
Дансны дугаар сонгосон банкных биш бол талбар улаанаар тодорч ийм алдаа гарна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (х. 73)
- Гадаад шилжүүлэг (SWIFT) (х. 86)

Гүйлгээний загвар

Хадгалсан загвараар хүлээн авагчийн мэдээллийг дахин бөглөхгүйгээр шилжүүлнэ.


ДЭЛГЭЦ 1/2 Загвар сонгох

Цэсний зам Шилжүүлэг → загварын дүрс, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Шилжүүлэг → Загварын жагсаалт



1. **Загвар**
   Шилжүүлэг цэсийн дээд хэсгийн загварын дүрсийг дарна.
2. **Загвар сонгох**
   Хадгалсан загвараа дарна.
3. **Загвар нэмэх**
   Шинэ загвар үүсгэнэ.

Дүн, баталгаажуулах



1. **Дүн**
   Шилжүүлэх дүнгээ оруулна.
2. **Шилжүүлэх**
   Дүнгээ шалгаад дарна.
3. **Хүлээн авагч**
   Загвараас автоматаар бөглөгдөнө.
4. **Үргэлжлүүлэх**
   Хүлээн авагчийн мэдээллийг шалгаад дарна.

5 **Гүйлгээ хийх**
Мэдээллээ шалгаад дарна.

6 **Гүйлгээ амжилттай**
Шилжүүлэг хийгдлээ.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (х. 73)
- Тогтмол шилжүүлэг (х. 105)


Гадаад шилжүүлэг (SWIFT)

Гадаадын банкны данс руу SWIFT-ээр мөнгө шилжүүлнэ. «1/5 Шилжүүлэгч»-ээс хойших алхмын зургийг iPhone дээр авсан.

ДЭЛГЭЦ 1 / 8 **Валют, дүн**

Цэсний зам Шилжүүлэг → Гадаад таб
Үйлчилгээ → Байнга ашиглах → Гадаад шилжүүлэг
Үйлчилгээ → Бүгд → Шилжүүлэг → Гадаад шилжүүлэг





1 **Шилжүүлэг → Гадаад таб**
Доод цэсний Шилжүүлэг-ийг дарж, дээд хэсгийн Гадаад табыг сонгоно.


2 **Эсвэл Үйлчилгээ цэсээс**
Үйлчилгээ цэсний Байнга ашиглах хэсгийн Гадаад шилжүүлэг-ээс ч нээнэ.

3 **Валют**
Шилжүүлэх валютаа сонгоно.

4 **Дүн**
Шилжүүлэх дүнгээ оруулна.

5 **Шилжүүлэх**
Дарна.

Лимит, улс



1. **Гүйлгээний лимит**
   VISA Direct болон MoneyGram-ын нэг удаагийн, өдөр, 7 хоног, сарын лимит.

2. **Үргэлжлүүлэх**
   Дүн лимитэд багтаж байвал дарна.

3. **Улс хайх**
   Хүлээн авагчийн улсыг нэрээр нь хайна.

4. **Улс сонгох**
   Жагсаалтаас сонгоод Үргэлжлүүлэх-ийг дарна.


5 **Swift transfer**

Шимтгэл, хугацааг шалгаад сонгоно. Хүлээн авагч банкны SWIFT/BIC код хэрэгтэй. → MoneyGram илгээх, хүлээн авах · Илгээх (х. 93)

Moneygram-ыг сонговол MoneyGram илгээх дараалаар үргэлжилнэ.

Санамж: Валют болон шилжүүлэх улсаас хамааран гадаад гүйлгээний төрөл санал болгоно.

ДЭЛГЭЦ 3/8 1/5 Шилжүүлэгч



1 **Шилжүүлэх данс**

Мөнгө хасагдах дансаа сонгоно.


2 **Шилжүүлэгчийн мэдээлэл**


Нэр, регистр, утас, хаяг, данснаас хасагдах дүнгээ шалгана.

3 **Дараах**

Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 4/8 2/5 Хүлээн авагч банк






1 SWIFT код эсвэл банкны нэр
Хүлээн авагч банкаа SWIFT кодоор эсвэл нэрээр нь хайна.

2 SWIFT код
Хүлээн авагчаас авсан 8 эсвэл 11 оронтой кодыг оруулна.

3 Банкны мэдээлэл
Банкны нэр, хаяг автоматаар бөглөгдсөнийг шалгана.

4 Дараах
Банкны мэдээллээ шалгаад дарна.


ДЭЛГЭЦ 5/8 3/5 Хүлээн авагч



1 Хүлээн авагчийн мэдээлэл
Данс эсвэл IBAN, нэр, хаягийг бүртгэлтэй ёсоор нь, латинаар оруулна.


2 Үргэлжлүүлэх
Мэдээллээ шалгаад дарна.


ДЭЛГЭЦ 6/8 4/5 Төлбөрийн зориулалт



1. **Төлбөрийн зориулалт**
   Юуны төлбөр болохыг англиар, товчлолгүй бичнэ.
2. **Файл хавсаргах**
   Нэхэмжлэх, гэрээ зэрэг баримтаа хавсаргана.
3. **Зориулалтын ангилал**
   Үндсэн болон дэд зориулалтаа жагсаалтаас сонгоно.
4. **Дараах**
   Зориулалтаа бөглөөд дарна.

ДЭЛГЭЦ 7/8 5/5 Шимтгэл






1. **Шимтгэлийн төрөл**
   Шимтгэлийг хэн төлөхийг сонгоно: зөвхөн эхний дамжуулагч банкных, бүх банкных, эсвэл хариуцахгүй.
2. **Шимтгэлийн задаргаа**
   Банкны, интернэт банкны, дамжуулагч банкны шимтгэл, шилжих хугацаа.
3. **Нийт хасагдах дүн**
   Данснаас хасагдах нийт дүнгээ шалгана.
4. **Үргэлжлүүлэх**
   Нийт дүнгээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 8/8

Гүйлгээ баталгаажуулах



1. **Мэдээлэл шалгах**
   Шилжүүлэгч, хүлээн авагч, дүнгээ дахин шалгана.
2. **Гүйлгээ хийх**
   Дарж шилжүүлнэ. Дараа нь HID Approve аппаар баталгаажуулна.

Санамж

- Банкны шимтгэл 20,000₮, дамжуулагч банкны шимтгэл тусдаа тооцогдоно. Шилжих хугацаа ажлын 1-3 хоног.
- Хүлээн авагчийн нэр, данс, хаягийг банкинд бүртгэлтэй ёсоор нь, товчлолгүй оруулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- MoneyGram илгээх, хүлээн авах (х. 93)
- Валютын арилжаа (х. 101)


MoneyGram илгээх, хүлээн авах


MoneyGram-аар гадаад руу мөнгө илгээх, гадаадаас илгээсэн мөнгийг нууц дугаараар дансандаа хүлээн авна. «Илгээх» хэсгийн зургийг iPhone дээр авсан.

Илгээх

ДЭЛГЭЦ 1/7 Улс, төрөл


Цэсний зам Шилжүүлэг → Гадаад таб → дүн → Шилжүүлэх → улс → Moneygram






1. **Улс хайх**
   Хүлээн авагчийн улсыг нэрээр нь хайна.
2. **Улс сонгох**
   Жагсаалтаас сонгоод Үргэлжлүүлэх-ийг дарна.
3. **Moneygram**
   Шимтгэл 8 USD, 10 минутад хүрнэ. Хүлээн авагчийн овог, нэрээр илгээнэ.

ДЭЛГЭЦ 2/7 1/4 Гүйлгээ хийх





1 Улс, дүн
Илгээх эсвэл хүлээн авах дүнгээр тооцохыг сонгож дүнгээ оруулна.


Урамшууллын код байвал оруулна. Загвараар гүйлгээ хийх-ийг асааж хадгалсан загвараа ашиглана.


2 Дараах
Дүнгээ шалгаад дарна.

3 Луйврын анхааруулга
Танихгүй хүнд, баталгаагүй зорилгоор мөнгө илгээхгүй байх анхааруулгыг уншина.

4 Ойлголоо
Анхааруулгатай танилцаад дарна.

ДЭЛГЭЦ 3/7 2/4 Илгээх төрөл





1 Илгээх төрөл
Бэлнээр авах, банкны данс руу эсвэл хэтэвч рүү илгээх.


2 Account Deposit
Хүлээн авагчийн банкны данс руу илгээх бол сонгоно.

3 Шимтгэл, нийт дүн
Гүйлгээний шимтгэл, нийт дүн, ханшийг шалгана.

4 Үргэлжлүүлэх
Шимтгэлээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 4/7

3/4 Хүлээн авагч





1 Хүлээн авагчийн мэдээлэл
Овог, нэр, дансны дугаар, Routing number, дансны төрлийг банкны бүртгэлтэй ёсоор оруулна.

2 Үргэлжлүүлэх
Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 5/7

4/4 Гүйлгээний зориулалт





1 Шилжүүлэх данс
Мөнгө хасагдах дансаа сонгоно.


2 Дүн, ханш
Данснаас хасагдах нийт дүн, MoneyGram-ын шимтгэл, ханшийг шалгана.

3 Мэдэгдэл авах
Асааж гүйлгээний мэдэгдэл авах утас эсвэл и-мэйлээ сонгоно.

4 Дараах
Зориулалтаа бөглөөд дарна.

ДЭЛГЭЦ 6/7

Баталгаажуулах




1. **Гүйлгээ хийх**
   Шилжүүлэгч, хүлээн авагч, дүнгээ шалгаад дарна.

2. **MoneyGram-ын нөхцөл**
   Үйлчилгээний нөхцөлтэй танилцана.

3. **Зөвшөөрөх**
   Нөхцөлийг зөвшөөрч гүйлгээг үргэлжлүүлнэ.

4. **HID Approve аппаар батлах**
   Аюулгүй байдлын үүднээс утсан дээрх HID Approve аппад ирсэн мэдэгдлийг нээж гүйлгээг зөвшөөрнө.

ДЭЛГЭЦ 7/7 **Амжилттай**




1 **Гүйлгээ амжилттай**
Хүлээн авагчид өгөх нууц дугаар гарна. Бэлнээр авах төрөлд хүлээн авагч энэ дугаараар мөнгөө авна.

Санамж
- MoneyGram-ын нэг удаагийн лимит 10,000 USD.
- Гүйлгээг HID Approve аппаар баталгаажуулна.

Хүлээн авах

ДЭЛГЭЦ 1/5 **Хүлээн авах**


Цэсний зам Шилжүүлэг → Гадаад таб → Хүлээн авах




1 Хүлээн авах

Шилжүүлэг цэсний Гадаад табаас Хүлээн авах-ыг дарна.

ДЭЛГЭЦ 2/5 1/2 Гүйлгээний мэдээлэл





1 Нууц дугаар


Илгээгчээс авсан гүйлгээний нууц дугаарыг оруулна.

2 Дараах

Дарахад гүйлгээний мэдээлэл хайгдана.

ДЭЛГЭЦ 3/5


2/2 Хүлээн авах мэдээлэл



1. **Шилжүүлэгчийн мэдээлэл**
   Шилжүүлэгчийн улс, нэр, шилжүүлсэн огноо, хүлээн авах дүн автоматаар харагдана.
2. **Хүлээн авах данс**
   Мөнгө орох дансаа сонгоно.
3. **Өөр валюттай данс**
   Гүйлгээний валютаас өөр валюттай данс сонговол дансны валютаар хөрвүүлсэн дүн, банкны ханш харагдана.
4. **Дараах**
   Мэдээллээ шалгаад дарна.


ДЭЛГЭЦ 4/5

Гүйлгээ баталгаажуулах



1. **Мэдээлэл шалгах**
   Нууц дугаар, хүлээн авах дүн, данс, ханшаа шалгана.
2. **Гүйлгээ хийх**
   Дарж мөнгөө хүлээн авна.

ДЭЛГЭЦ 5/5 **Амжилттай**



1 **Гүйлгээ амжилттай**
Хүлээн авсан дүн, илгээгч, данс болон дансны валютаар орсон дүн харагдана.

2 **Дуусгах**
Дарж гүйлгээг дуусгана.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Гадаад шилжүүлэг (SWIFT) (x. 86)
- Валютын арилжаа (x. 101)


Валютын арилжаа

Өөрийн данс хооронд валют арилжих хүсэлтийг банкинд илгээнэ. Ханшийг банк тогтоож дүнг оруулна.

ДЭЛГЭЦ 1/4 Хүсэлт эхлүүлэх


Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Шилжүүлэг → Арилжаа хийх





1. **Арилжаа хийх**
   Шилжүүлэг ангиллаас сонгоно.
2. **Хүсэлт илгээх**
   Шинэ хүсэлт үүсгэнэ.

Төрөл, данс



1. **Гүйлгээний төрөл**
   Дарж жагсаалтыг нээнэ.

2. **Өөрийн данс хооронд**
   Өөрийн данс хооронд арилжих бол сонгоно.

   Бусдын данс хооронд, гадаад шилжүүлэг сонголт ч бий.


3. **Шилжүүлэх данс**
   Валют хасагдах дансаа сонгоно.

4. **Хүлээн авах данс**
   Валют орох дансаа сонгох жагсаалтыг нээнэ.

5 Өөр валюттай данс

Өөр валюттай дансаа сонгоно, жишээ нь HKD данс.

дэлгэц 3/4 **Дүн, утга**



1 Илгээх дүн

Данснаас хасагдах дүнгээ оруулна.

2 Хүлээн авах дүн

Банк ханшаар тооцож оруулна.

3 Гүйлгээний утга

Утгаа бичнэ.

4 Холбогдох утас


Арилжааны хэлтэстэй холбогдох дугаар.

5 Хүсэлт илгээх

Дарж илгээнэ.

ДЭЛГЭЦ 4/4

Хүсэлт илгээгдлээ



1 **Амжилттай**
Хүсэлт банкинд илгээгдлээ.

2 **Арилжааны жагсаалт харах**
Илгээсэн хүсэлтүүдээ харна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Гадаад шилжүүлэг (SWIFT) (x. 86)
- Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (x. 73)


Тогтмол шилжүүлэг

Сонгосон давтамжаар, тогтсон хугацаанд шилжүүлэг автоматаар хийгдэхээр бүртгэнэ.

ДЭЛГЭЦ 1/4 Хүлээн авагч, дүн

Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Шилжүүлэг → Тогтмол шилжүүлэг





1. **Тогтмол шилжүүлэг бүртгэх**
   Жагсаалтын доорх товчийг дарна.


2. **Өөрийн данс**
   Өөрийн данс руу бол сонгоно. Бусдын данс руу бол IBAN оруулна.

3. **Шилжүүлэх дүн**
   Нэг удаад шилжих дүнгээ оруулна.

4. **Гүйлгээний утга**
   Утгаа бичих эсвэл бэлэн утгаас сонгоно.

ДЭЛГЭЦ 2/4

Давтамж, хугацаа



1 **Давтамж**

Нэг удаа, долоо хоног бүр, сар бүр эсвэл өдөр бүрээс сонгоно.

2 **Эхлэх огноо**

Огноогоо гүйлгэж Сонгох-ыг дарна.

Анх сонгосон өдрөөр сар бүр давтагдана.

3 **Дуусах огноо**


Огноогоо гүйлгэж Сонгох-ыг дарна.

4 **Үргэлжлүүлэх**

Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 3/4

Бүртгэх



1 **Шалгах**

Данс, дүн, давтамж, хүчинтэй хугацаагаа шалгана.

2 **Бүртгэх**


Дарж бүртгэнэ.

3 **Жагсаалт харах**

Амжилттай бүртгэгдсэний дараа жагсаалтаа харна.

ДЭЛГЭЦ 4/4

Засах, устгах



1 Тогтмол шилжүүлэг сонгох

Жагсаалтаас дарна.

2 Мэдээлэл засах

Хүлээн авах данс, дүн, утга, давтамж, огноог өөрчлөөд Хадгалах-ыг дарна.

3 Устгах

Баруун дээд булангийн хогийн савны дүрсийг дарна.

4 Устгахыг батлах

Устгах-ыг дарна.

5 **Устгагдлаа**

Цаашид шилжүүлэг хийгдэхгүй.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Өөрийн данс руу, дотоод шилжүүлэг (х. 73)
- Гүйлгээний загвар (х. 83)


Карт


Виртуал карт захиалах


Зөвхөн интернэт худалдан авалтад зориулсан биет бус картыг аппаас захиална. Нэг харилцагч 5 хүртэл виртуал карт эзэмшинэ.

ДЭЛГЭЦ 1/3 Картын төрөл

Цэсний зам Нүүр хуудас → Карт → Шинэ карт захиалах → Виртуал карт үүсгэх









1 Карт

Нүүр хуудасны Карт цэсийг дарна.

Карт хуудсанд Дебит, Кредит, Виртуал таб болон доор нь Шинэ карт захиалах товч байна. Энэ хуудас аюулгүй байдлын үүднээс дэлгэцийн зураг авахыг хаадаг тул зураг оруулаагүй.

2 Виртуал карт үүсгэх

Шинэ карт захиалах-ын дараа сонгоно.


3 Visa эсвэл Mastercard

Картын төрлөө сонгоно.

4 Үргэлжлүүлэх

Картын загвар, тайлбарыг уншаад дарна.

Хугацаа, валют, данс



1. **Хугацаа**
   Картын хугацаа, үнийг сонгоно.


2. **Валют**
   MNT эсвэл USD сонгоно.

3. **Холбох данс**
   Карт холбогдох дансаа сонгоно.

4. **Үргэлжлүүлэх**
   Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 3/3

Захиалгын дэлгэрэнгүй



1 Захиалга шалгах

Төлбөр төлөх данс, картын төрөл, валют, хугацаа, үнийг шалгана.

2 Үргэлжлүүлэх

Дарж захиалгаа баталгаажуулна.

⚠ Сүүлийн алхам: дарахад картын үнэ данснаас хасагдана

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Дебит карт захиалах (х. 115)


Дебит карт захиалах


Биет дебит картаа аппаас захиалж, хүргүүлэх эсвэл сонгосон салбараас очиж авна.

ДЭЛГЭЦ 1/7 Карт сонгох


Цэсний зам Нүүр хуудас → Карт → Шинэ карт захиалах → Дебит карт захиалах











1 Карт

Нүүр хуудасны Карт цэсийг дарна.

Карт хуудсанд Шинэ карт захиалах товчийг дарна.

2 Дебит карт захиалах

Шинэ карт захиалах-ын дараа сонгоно.

3 Картын төрөл

Visa эсвэл UnionPay сонгоно.


4 Картын загвар

Хажуу тийш гүйлгэж загвараа сонгоно.

5 Үргэлжлүүлэх

Төрөл, загвараа сонгоод дарна.

Хугацаа, валют, данс



1. **Хугацаа**
   Картын хугацаа, хураамжийг сонгоно.


2. **Валют**
   MNT эсвэл USD сонгоно.

3. **Холбох данс**
   Карт холбогдох дансаа сонгоно.

4. **Үргэлжлүүлэх**
   Мэдээллээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 3/7

Картын нэр




1 Карт дээр хэвлэгдэх нэр


Латин үсгээр нэрээ шалгаж засна.

2 Үргэлжлүүлэх

Нэрээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 4/7 Хүлээн авах суваг





1. **Хүргэлтээр авах**
   Ажлын 3-5 хоногт хаягаар хүргэнэ.

2. **Хүргэлтийн хаяг**
   Хүргэлтээр авах бол хот, дүүрэг, хороо, хаяг, утасны дугаараа оруулна.

3. **Салбараас очиж авах**
   Карт бэлэн болоход мэдэгдэл ирсний дараа салбараас авна.

4. **Салбар хайх**
   Нэрээр хайх эсвэл хот, дүүргээр шүүнэ.


5. **Салбар сонгох**
   Жагсаалтаас салбараа дарна.

6. **Салбарын мэдээлэл**
   Байршил, утасны дугаарыг шалгана.

7. **Үргэлжлүүлэх**
   Хүлээн авах сувгаа сонгоод дарна.

ДЭЛГЭЦ 5/7

Захиалгын дэлгэрэнгүй



1 **Захиалга шалгах**

Төлбөр төлөх данс, карт, нэр, хугацаа, үнэ, салбарын мэдээллээ шалгана.

2 **Төлбөр төлөх данс**


Хураамж хасагдах дансаа сонгоно.

3 **Үргэлжлүүлэх**

Дарж захиалгаа баталгаажуулна.

⚠ Сүүлийн алхам: дарахад 20,000₮ хураамж данснаас хасагдана


ДЭЛГЭЦ 6/7 Карт захиалагдлаа



1 **Карт амжилттай захиаллаа**

Карт ажлын 3-5 хоногт хэвлэгдэж бэлэн болно. Картын үнэ, салбарын мэдээлэл харагдана.

ДЭЛГЭЦ 7/7 Захиалгын явц



1 **Гүйлгээний явц**

Карт хуудсанд шинэ картаа дарж захиалга хэвлэгдсэн эсэхийг харна.

> Санамж
>
> Захиалгыг баталгаажуулахад картын хураамж сонгосон данснаас шууд хасагдана.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Виртуал карт захиалах (х. 111)


Зээл


Зээлийн төрлүүд

Зээл цэсэд 7 төрлийн зээл байна. Төрөл бүр өөрийн шаардлагатай тул эхний дэлгэцээс нөхцөлөө шалгана.

ДЭЛГЭЦ 1/6 Зээл цэс


Цэсний зам Нүүр хуудас → Зээл, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Зээл





1. **Зээл**
   Нүүр хуудасны Зээл цэсийг дарна.
2. **Зээлийн төрөл**
   Цалингийн, тэтгэврийн, посын орлого, цахим худалдан авалт, хадгаламж барьцаалсан, автомашины зээл болон зээлийн эрх.
3. **Миний зээл**
   Бүртгэлтэй зээлийн данс энд харагдана.

Цалингийн, тэтгэврийн зээл




1 **Цалингийн зээл**
Зээл цэсээс сонгоно. → Цалингийн зээл (х. 129)

2 **Шаардлага**
ХХБ-ны дансаар цалин авдаг байх шаардлагатай.

3 **Тэтгэврийн зээл**
Зээл цэсээс сонгоно.


4 **Шаардлага**
ХХБ-ны дансаар тэтгэвэр авдаг байх шаардлагатай.

ДЭЛГЭЦ 3/6 Посын орлого барьцаалсан зээл



1. **Посын орлого барьцаалсан зээл**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Лавлах утсаар холбогдох**
   1800-1977 дугаарт холбогдож мэдээллээ шалгуулна.


ДЭЛГЭЦ 4/6 Цахим худалдан авалтын зээл




1. **Цахим худалдан авалтын зээл**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Зээлийн нөхцөл**
   Боломжит дүн, сарын хүү, хугацаа.
3. **Нэхэмжлэхийн дугаар оруулах**
   Худалдан авалтын нэхэмжлэхийн дугаараар зээл хүснэ.

ДЭЛГЭЦ 5/6

Хадгаламж барьцаалсан зээл







1. **Хадгаламж барьцаалсан зээл**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Хугацаатай хадгаламж хэрэгтэй**
   Хугацаатай хадгаламжийн данс байхгүй бол энэ зээлийг авах боломжгүй.
3. **Данс нээх**
   Хугацаатай хадгаламжийн данс нээнэ. → Данс нээх (х. 52)

ДЭЛГЭЦ 6/6

Зээлийн эрх





1. **Зээлийн эрх**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Нийлүүлэлтийн сүлжээ, Зээлийн эрх**
   Хоёр табаас сонгоно.
3. **Шилжүүлгийн мэдээлэл**
   Зээлийн эрхийн данснаас хүлээн авагч, дүн, утгаа оруулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Цалингийн зээл (x. 129)
- Автомашины зээл (x. 141)

Цалингийн зээл


ХХБ-ны дансаар цалин авдаг харилцагч зээлийн эрхээ Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээс мэдээлэл татуулж тооцоолуулаад, цалингийн зээлээ аппаас авна.

ЕРӨНХИЙ ДАРААЛАЛ

1. Эрх тооцоолох
2. ХУР зөвшөөрөл
3. Лавлагааны хураамж
4. Дүн, хугацаа
5. Төлөх өдөр, данс
6. Холбоо барих хүн
7. Гэрээ
8. Баталгаажуулах


ДЭЛГЭЦ 1/11 Эрх тооцоолох

Цэсний зам Зээл → Цалингийн зээл, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Зээл → Цалингийн зээл



1. **Цалингийн зээл**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Зээлийн нөхцөл**
   Боломжит дүн, сарын хүү, хугацаа.
3. **Эрх тооцоолох**
   Дарж зээлийн эрхээ тооцоолуулна.

Мэдээлэл шалгах



1. **Холбоо барих мэдээлэл**
   Утас, и-мэйл, хаяг шинэчлэгдсэн эсэхийг шалгана.


   Утасны дугаар заавал таны өөрийн нэр дээр байх ёстой.

2. **Мэдээлэл шинэчлэх**
   Өөрчлөгдсөн бол шинэчилнэ.

3. **Үгүй, Үргэлжлүүлэх**
   Мэдээлэл зөв бол дарна.

ДЭЛГЭЦ 3/11

ХУР-аас мэдээлэл татах




1. **Татах мэдээлэл**
   Нийгмийн даатгал, иргэний үнэмлэх, оршин суугаа хаягийн лавлагаа.

2. **Тийм, Үргэлжлүүлэх**
   Мэдээлэл татахыг зөвшөөрнө.

3. **OTP код**
   Бүртгэлтэй утасны дугаарт ирсэн OTP кодыг оруулна.

Лавлагааны хураамж



1 Хураамж төлөх данс

Зээлийн мэдээллийн сангийн лавлагааны 1,000₮ хураамж төлөх дансаа сонгоно.

Лавлагаа авснаар зээлийн хэмжээ тань тооцоологдоно. 72 цагийн дотор дахин лавлагаа авахад хураамжгүй.

2 Тооцоолол эхэллээ


«Зээлийн тооцоолол хийгдэж эхэллээ» гэсэн мэдэгдэл гарна. Тооцоолол дуусахад утсанд тань мэдэгдэл ирнэ.

3 Цалингийн зээл цэс рүү шилжих

Дарж зээлийн хуудас руу буцна.

ДЭЛГЭЦ 5/11

Зээл авах



1 Боломжит зээлийн дүн

Тооцоологдсон дүн, сарын хүү, хугацаа болон эрхийн хүчинтэй хугацаа харагдана.

2 Зээл авах

Дарж зээлийн хүсэлт бөглөнө.


3 Бусад банкны зээлээс хаах

Бусад банкны үлдэгдэлтэй зээлээ хааж зээлийн дүнгээ өсгөх бол асаана. Энэ тохиолдолд ажилтан тантай холбогдоно.

4 Үргэлжлүүлэх

Дарж дүн, хугацаагаа сонгоно.

Дүн, хугацаа



1 Зээлийн хэмжээ

Хасах, нэмэх товч эсвэл гулсуураар зээлийн дүнгээ сонгоно.

2 Хугацаа

Зээлийн хугацааг сараар сонгоно.

3 Сарын төлөлт


Сарын төлөлт, хүү, шимтгэл, барьцааны хураамж сонголтоор шинэчлэгдэнэ.

Тооцоолол зээлийн судалгааны явцад өөрчлөгдөж болно.

4 Үргэлжлүүлэх

Дүн, хугацаагаа шалгаад дарна.

Төлөх өдөр, данс, салбар



1 Сард төлөх давтамж
Дарж жагсаалтыг нээнэ.

2 Давтамж сонгох
Сард 1 эсвэл 2 удаа төлөхөөс сонгоно.

3 Төлбөр төлөх өдөр
Дарж жагсаалтыг нээнэ.


4 Өдөр сонгох
Сарын аль өдөр төлөхөө сонгоно, жишээ нь сар бүрийн 25-нд.

5 **Зээл олгох данс**
Зээл орох дансаа сонгоно.

6 **Салбар сонгох**
Хүсэлтээ илгээх салбараа сонгох бол асаана.

7 **Үргэлжлүүлэх**
Сонголтоо шалгаад дарна.


ДЭЛГЭЦ 8/11 **Салбар**



1 **Салбар сонгох**
Зээлийн хүсэлт илгээх салбараа сонгоно. Салбарын хаяг, утасны дугаар харагдана.

2 **Үргэлжлүүлэх**
Дарна.

Яаралтай үед холбоо барих хүн



1 Таны хэн болох

Холбоо барих хүн таны хэн болохыг жагсаалтаас сонгоно.

2 Регистрийн үсэг

Үсгийн нүдийг дарж гарч ирэх самбараас регистрийн дугаарын үсгийг сонгоно.

3 Хүний мэдээлэл

Овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг оруулна.

4 Үргэлжлүүлэх

Дарна.

Хүсэлтээ цуцлах бол Хүсэлт цуцлах-ыг дарна.


5 **Хоёр дахь холбоо барих хүн**

Хоёр дахь хүний мэдээллийг мөн адил оруулна.

6 **Үргэлжлүүлэх**

Дарна.

Гэрээ




1. **Цалингийн зээлийн гэрээ**
   Гэрээ, төлбөрийн хуваарийг доош гүйлгэж бүтэн уншина.
2. **Гэрээтэй танилцсан ба зөвшөөрч байна**
   Гэрээний төгсгөлд хүрээд тэмдэглэнэ.
3. **Үргэлжлүүлэх**
   Дарна.
4. **Барьцааны гэрээ**
   Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг мөн гүйлгэж уншаад тэмдэглэнэ.

5 **Үргэлжлүүлэх**
Дарна.

6 **Зээлийн бүтээгдэхүүний мэдээллийн хуудас**
Мэдээллийн хуудастай танилцаад тэмдэглэнэ.

ДЭЛГЭЦ 11/11 Баталгаажуулах



1 **Үргэлжлүүлэх**
Дарахад бүртгэлтэй утасны дугаарт тань SMS код ирнэ. Кодоо оруулж зээлийн хүсэлтээ баталгаажуулна.

⚠ Цааших алхмууд энэ зааварт ороогүй

Санамж

- Зээлийн мэдээллийн сангийн лавлагаанд 1,000₮ хураамж төлнө. 72 цагийн дотор дахин лавлагаа авахад хураамжгүй.
- ХУР-аас мэдээлэл татах болон зээлийн хүсэлтийг утсанд ирэх кодоор баталгаажуулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Зээлийн төрлүүд (х. 124)
- Автомашины зээл (х. 141)

Автомашины зээл

Автомашины зээлийн боломжит дүнгээ Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээс мэдээлэл татуулж тооцоолуулна.

ДЭЛГЭЦ 1/3 Эрх тооцоолох


Цэсний зам Зээл → Автомашины зээл, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Зээл → Автомашины зээл



1. **Автомашины зээл**
   Зээл цэсээс сонгоно.
2. **Зээлийн нөхцөл**
   Боломжит дүн, сарын хүү, хугацаа.
3. **Эрх тооцоолох**
   Дарж зээлийн эрхээ тооцоолуулна.

ДЭЛГЭЦ 2/3

Мэдээлэл шалгах



1 Холбоо барих мэдээлэл

Утас, и-мэйл, хаяг шинэчлэгдсэн эсэхийг шалгана.

2 Мэдээлэл шинэчлэх


Өөрчлөгдсөн бол шинэчилнэ.

3 Үгүй, Үргэлжлүүлэх

Мэдээлэл зөв бол дарна.

ДЭЛГЭЦ 3/3

ХУР-аас мэдээлэл татах



1 Татах мэдээлэл

Нийгмийн даатгал, иргэний үнэмлэх, оршин суугаа хаягийн лавлагаа.

2 Тийм, Үргэлжлүүлэх

Мэдээлэл татахыг зөвшөөрч зээлийн эрхээ тооцоолуулна.

⚠ Цааших алхмууд энэ зааварт ороогүй

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Зээлийн төрлүүд (x. 124)


Төлбөр

Утасны дата, нэгж

Гар утасны дугаартаа дата багц болон нэгж аппаас худалдан авна.

ДЭЛГЭЦ 1/2 **Дугаар, багц**

Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Төлбөр → Нэгж, дата



1 **Нэгж, дата**
Төлбөр ангиллаас сонгоно.

2 **Утасны дугаар**
Дугаараа оруулахад оператор нь автоматаар гарна.


3 **Дата, Нэгж**
Дата багц эсвэл нэгжээ сонгох таб.

4 **Нэгж**
Зарим оператор, дугаарт нэгж авах боломжгүй байж болно.

5 **Багц сонгох**
Үнэ, дата, хоногийг харьцуулж сонгоно.

ДЭЛГЭЦ 2/2

Төлбөр төлөх



1 Төлбөрийн мэдээлэл

Төлөх данс, дүн, багц, шимтгэлээ шалгана.

Энэ үйлчилгээнд НӨАТ-ын баримт олгогдохгүй.

2 Төлбөр төлөх

Дарж төлнө.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Билл төлбөр (х. 147)

Билл төлбөр

Цахилгаан, дулаан, СӨХ зэрэг байгууллагын биллээ бүртгэж, нэхэмжлэхээ аппаас төлнө. Нүүр хуудасны Хэрэглээ товчоор ч нээгдэнэ. Энэ хэсгийн зургийг iPhone дээр авсан.

ДЭЛГЭЦ 1/2 Билл бүртгэх

Цэсний зам Нүүр хуудас → Хэрэглээ, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Төлбөр → Утас, хэрэглээний төлбөр



1 **Хэрэглээ**

Нүүр хуудасны Хэрэглээ цэсийг дарна.

Үйлчилгээ → Бүгд → Төлбөр → Утас, хэрэглээний төлбөр-өөр, эсвэл Үйлчилгээ цэсний Байнга ашиглах хэсэгт нэмсэн бол тэндээс ч нээгдэнэ.

2 **Билл бүртгэх**

Бүртгэсэн билл байхгүй бол эндээс шинээр бүртгэнэ.

3 **Биллер компани хайх**


Ангиллаа сонгоод байгууллагаа нэрээр нь хайна.

4 **Компани сонгох**

Жагсаалтаас байгууллагаа дарна.

5. **Хэрэглэгчийн дугаар**
   Байгууллагад бүртгэлтэй хэрэглэгчийн дугаараа оруулна.
6. **Биллийн нэр**
   Танихад хялбар нэр өгнө.
7. **Хадгалах**
   Дарж биллээ бүртгэнэ.
8. **Бүртгэл амжилттай**
   Билл хадгалагдлаа.

Билл төлөх



1. **Билл сонгох**
   Бүртгэсэн биллээ дарна.

2. **Хүлээгдэж буй билл байхгүй**
   Төлөх нэхэмжлэл үүсээгүй бол ийм анхааруулга гарна.

3. **Нэхэмжлэх сонгох**
   Төлөх нэхэмжлэхээ дугуйг дарж сонгоно.

4. **Засах**
   Хэсэгчлэн төлөх бол дүнгээ өөрчилнө.

5 **Сонгогдсон нэхэмжлэх**
Төлөх дүн шинэчлэгдэнэ.

6 **Нийт дүн, шимтгэл**
Нийт төлөх дүн, 100₮ шимтгэлийг шалгана.

Хүлээн авагч бусад банкны данстай бол нэмэлт 200₮ шимтгэл авч болно.

7 **Төлбөр төлөх**
Дарж төлнө.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Утасны дата, нэгж (х. 144)
- Татвар төлөх (х. 152)

Татвар төлөх

Нэхэмжлэлийн дугаараар татварын өрөө хайж, бүтэн эсвэл хэсэгчлэн төлнө. Энэ хэсгийн зургийг iPhone дээр авсан.

ДЭЛГЭЦ 1/5 Нэхэмжлэл хайх

Цэсний зам Үйлчилгээ → Байнга ашиглах → Татвар, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Төлбөр → Татвар




1 Татвар
Үйлчилгээ цэсний Байнга ашиглах хэсгээс сонгоно.

2 Нэхэмжлэл хайх төрөл
Хайх төрлөө, жишээ нь нэхэмжлэлийн дугаарыг сонгоно.

3 Нэхэмжлэлийн дугаар
Дугаараа оруулахад татварын мэдээлэл хайгдана.

ДЭЛГЭЦ 2/5

Татварын мэдээлэл



1 Татвар төлөгч

Нэр, татвар төлөгчийн дугаараа шалгана.

2 Татварын нэхэмжлэл

Татварын төрөл, огноо, хүлээн авагчийн данс, дүн.

3 Засах

Хэсэгчлэн төлөх бол дүнгээ өөрчилнө.

4 Төлөх дүн

Төлөх дүнгээ оруулаад Үргэлжлүүлэх-ийг дарна.

5 Сонгосон

Төлөх нэхэмжлэл ногоон болж сонгогдоно.

Бүх нэхэмжлэлийг нэг дор төлөх бол Бүгдийг сонгох-ыг дарна.

6 Нийт дүн, шимтгэл


Нийт төлөх дүн болон 100₮ шимтгэлийг шалгана.

7 Үргэлжлүүлэх

Дүнгээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 3/5


Төлбөр төлөх



1. **Төлбөр төлөх данс**
   Мөнгө хасагдах дансаа сонгоно.
2. **Шилжүүлэх дүн**
   Татварын дүн дээр шимтгэл нэмэгдсэн дүн.
3. **Төлбөр төлөх**
   Дарж төлнө.

ДЭЛГЭЦ 4/5


Давхар баталгаажуулалт



1. **HID Approve аппаар батлах**
   Аюулгүй байдлын үүднээс утсан дээрх HID Approve аппаа нээж гүйлгээг Approve-оор зөвшөөрнө.

   Зөвшөөрөх хүртэл дэлгэц дээр Баталгаажуулалт хүлээгдэж байна гэж харагдана.

ДЭЛГЭЦ 5/5 **Амжилттай**



1 **Гүйлгээ амжилттай**
Татвар төлөгдсөнийг мэдэгдэнэ. Өөр татвар төлөх-өөр дараагийн төлбөрөө хийнэ.

Санамж

- Татвар төлөх гүйлгээ бүрт 100₮ шимтгэл тооцогдоно.
- Гүйлгээг HID Approve аппаар баталгаажуулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Гаалийн төлбөр (х. 156)
- Билл төлбөр (х. 147)

Гаалийн төлбөр

Баркод, нэхэмжлэлийн эсвэл регистрийн дугаараар гаалийн төлбөрийн нэхэмжлэл хайж төлнө. Энэ хэсгийн зургийг iPhone дээр авсан.

ДЭЛГЭЦ 1/4 Нэхэмжлэл хайх

Цэсний зам Үйлчилгээ → Байнга ашиглах → Гааль, эсвэл Үйлчилгээ → Бүгд → Төлбөр → Гааль






1 Гааль
Үйлчилгээ цэсний Байнга ашиглах хэсгээс сонгоно.


2 Хайх төрөл
Баркод, нэхэмжлэлийн дугаар эсвэл регистрийн дугаараас сонгоод дугаараа оруулна.


ДЭЛГЭЦ 2/4 Нэхэмжлэлийн мэдээлэл



1. **Төлбөр төлөгч**
   Нэр, регистрийн дугаараа шалгана.
2. **Нэхэмжлэл сонгох**
   Төлөх нэхэмжлэлээ сонгоно. Засах-аар дүнг өөрчилж болно.
3. **Үргэлжлүүлэх**
   Нийт дүн, шимтгэлээ шалгаад дарна.

ДЭЛГЭЦ 3/4 Баталгаажуулах






1. **Төхөөрөмж сонгох**
   HID Approve суулгасан утсаа сонгоно.
2. **Approve**
   Аюулгүй байдлын үүднээс HID аппад гарсан гүйлгээний мэдээллийг шалгаад зөвшөөрнө.

   Таны хийгээгүй гүйлгээ бол Decline-ийг дарна.

ДЭЛГЭЦ 4/4 **Амжилттай**



1 Гүйлгээ амжилттай

Нэхэмжлэл төлөгдсөнийг мэдэгдэнэ. Өөр дугаараар хайх-аар дараагийн төлбөрөө хийнэ.

Санамж

- Гүйлгээ бүрт 100₮ шимтгэл тооцогдоно.
- Гүйлгээг HID Approve аппаар баталгаажуулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Татвар төлөх (х. 152)
- Билл төлбөр (х. 147)


QR төлбөр

QR төлбөр

Худалдааны цэгийн QR кодыг уншуулж төлнө. Уншуулахын тулд аппад камер ашиглах зөвшөөрөл өгсөн байх ёстой.

ДЭЛГЭЦ 1/2 Камерын зөвшөөрөл

Цэсний зам Доод цэс → QR төлбөр




1. **QR төлбөр**
   Доод цэснээс дарна. Анх удаа камер ашиглах зөвшөөрөл асууна.

2. **Камер ашиглахыг зөвшөөрөх**
   Утас камер ашиглах зөвшөөрөл асуухад While using the app эсвэл Only this time-ийг сонгоно.

3. **Камер ашиглах зөвшөөрөл**
   Зөвшөөрөл өгөөгүй бол энэ дэлгэц гарна.

4. **Тохиргоо руу очих**
   Утасны тохиргооноос аппад камерын зөвшөөрөл олгоод буцаж орно.

ДЭЛГЭЦ 2/2 **QR уншуулах**



1 **QR код уншуулах**
Худалдааны цэгийн QR кодыг хүрээн дотор багтааж уншуулна.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Билл төлбөр (х. 147)


Бусад

Хүсэлт илгээх

Банкинд санал, гомдол, талархал болон бусад хүсэлтээ аппаас илгээнэ.

ДЭЛГЭЦ 1/3 Хүсэлтийн жагсаалт


Цэсний зам Үйлчилгээ → Бүгд → Бусад → Хүсэлтийн жагсаалт



1. **Хүсэлтийн жагсаалт**
   Бусад ангиллаас сонгоно.
2. **Мэдэгдэл, Хүсэлт**
   Хүсэлт табд илгээсэн хүсэлтүүд харагдана.
3. **Хүсэлт шинээр үүсгэх**
   Дарж шинэ хүсэлт бөглөнө.

ДЭЛГЭЦ 2/3

Хүсэлт бөглөх




1 Төрөл
Дарж жагсаалтыг нээнэ.

2 Төрөл сонгох
Санал, гомдол, талархал, багц ахиулах, маргаантай гүйлгээ гэх мэт төрлөөс сонгоно.

3 Тайлбар
Хүсэлтээ тодорхой бичнэ.

4 Үргэлжлүүлэх
Тайлбараа бичээд дарна.

ДЭЛГЭЦ 3/3 **Илгээх**



1. **Хүсэлт үүсгэх**
   Тайлбараа шалгаад дарна.
2. **Амжилттай илгээгдлээ**
   Хариу ирэхэд утас болон и-мэйлээр мэдэгдэнэ.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Мэдэгдэл (х. 165)


Google Pay холбох

Картаа Google Wallet-д холбож утсаараа төлбөр төлнө. Холболтыг Happy Pay аппаар хийнэ.

ДЭЛГЭЦ 1/1 Google Pay

Цэсний зам Үйлчилгээ → Google Pay





1. **Google Pay**
   Үйлчилгээ цэсээс дарна.
2. **Картаа Google Pay-д холбох**
   Happy Pay апп ашиглан картаа Google Wallet-д холбоно.
3. **Happy Pay-р холбох**
   Дарахад Happy Pay апп руу шилжинэ.

   ⚠ Цааших алхмууд Happy Pay апп дээр хийгдэнэ

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Виртуал карт захиалах (х. 111)

Мэдэгдэл

Гүйлгээ, нэвтрэлт, аюулгүй байдлын мэдэгдлээ аппаас харна.

ДЭЛГЭЦ 1/1 Мэдэгдлийн жагсаалт

Цэсний зам Нүүр хуудас → хонхны дүрс



1 Мэдэгдэл

Нүүр хуудасны хонхны дүрсийг дарна.

2 Мэдэгдэл, Хүсэлт

Банкны мэдэгдэл болон хүсэлтийн хариуг тусад нь харна.

3 Хайх

Мэдэгдлээ үгээр хайна.

4 Мэдэгдэл сонгох

Уншаагүй мэдэгдэл цэнхэр цэгтэй. Дарж дэлгэрэнгүйг нээнэ.

5 Дэлгэрэнгүй

Мэдэгдлийн бүтэн текст.

ХОЛБООТОЙ ЗААВАР


- Хэрэглэгчийн булан, тохиргоо (x. 168)


Хэрэглэгчийн булан, тохиргоо

Нүүр хуудасны профайлын дүрсээр хувийн мэдээлэл, мэдэгдэл, аюулгүй байдал, дансны тохиргоо руу орно.

ДЭЛГЭЦ 1 / 5 **Хэрэглэгчийн булан**

Цэсний зам Нүүр хуудас → зүүн дээд булангийн профайлын дүрс





1 Профайл

Нүүр хуудасны зүүн дээд булангийн дүрсийг дарна.

2 Миний мэдээлэл

Хувийн мэдээллээ харна.

3 Үндсэн мэдээлэл

Бүртгэлтэй утас, и-мэйл.

4 Бусад мэдээлэл


Ажил, албан тушаал, хаягаа Засах-аар шинэчилнэ.


5 Засах

Засах-ыг дарахад Бусад мэдээлэл хуудас нээгдэнэ. Мэдээллээ шинэчлээд Хадгалах-ыг дарна.

ДЭЛГЭЦ 2/5

Мэдэгдлийн тохиргоо






1 **Мэдэгдлийн тохиргоо**
Хэрэглэгчийн булангаас сонгоно.

2 **Идэвхжүүлэх**
Гүйлгээний мэдэгдлийн үйлчилгээнд бүртгүүлнэ.

ДЭЛГЭЦ 3/5

Аюулгүй байдал

Цэсний зам Хэрэглэгчийн булан → Аюулгүй байдлын тохиргоо



1 Аюулгүй байдлын тохиргоо

Хэрэглэгчийн булангаас сонгоно.

2 Тохиргоонууд

Нууц үг солих, давхар баталгаажуулалт, бүртгэлтэй төхөөрөмж, бүртгэл идэвхгүй болгох. → HID Approve бүртгүүлэх (х. 12)

HID Approve (MFA authenticator) бүртгэлгүй, эсвэл нэвтрэх үед HID бүртгүүлэх дэлгэцийг 3 удаа алгассан бол Давхар баталгаажуулалт-аас бүртгүүлнэ. Нэг хэрэглэгч HID-г зөвхөн нэг төхөөрөмж дээр бүртгүүлнэ.

3 Нууц үг солих


Аюулгүй байдлын тохиргооноос сонгоно.


4 Нууц үг оруулах

Одоогийн нууц үг, шинэ нууц үгээ оруулж, шинэ нууц үгээ давтаад Дараах-ыг дарна.

ДЭЛГЭЦ 4/5

Дансны тохиргоо






1 Дансны тохиргоо
Хэрэглэгчийн булангаас сонгоно.

2 Тохиргоонууд
Үндсэн данс, дансаа нуух, товч нэр, дансны нэгдсэн сан. → Данс, дансны тохиргоо (х. 33)

Ханш, бусад



1. **Ханшийн мэдээ**
   Бэлэн болон бэлэн бус ханшийг харна.

2. **Бэлэн, Бэлэн бус**
   Ханшийн төрлөө сонгоно.

3. **Салбар, АТМ хаяг байршил**
   Салбар, АТМ, мерчантын хаяг байршлыг харна.

4. **Түгээмэл асуулт хариулт**
   Утасны хөтөч дээр банкны вэб хуудас нээгдэнэ.

ХОЛБООТОЙ ЗААВАР

- Мэдэгдэл (х. 165)
- Аппад нэвтрэх (х. 4)